

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/052/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Алтай хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhand@audit.gov.mn

Аудитор: Г.Энхдэлгэр

Утас: 99002291 Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2026/052/НА-СТА-ТШЗ

## **АГУУЛГА**

Нэг. Хараат бус аудиторын санал, дүгнэлт

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Гурав. Аудитын илрүүлэлт

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлийн нэгтгэл



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

АДАГ. 02.15 № 105

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ж.САМБУУ  
ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Засаг даргын нөөц хөрөнгийн төсвөөс Засаг даргын Тамгын газрын нярвын дансаар дамжуулан 23,758.6 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн бөгөөд анхан шатны баримт хангалтгүй,
- Нотариатын үйлчилгээний нэмэгдлийг үндсэн цалингийн 20.0 хувиар тооцож 3,079.2 мянган төгрөгийг олгосон,
- Засаг даргын Тамгын газрын түрээсийн орлогыг төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 27 дугаар зүйлийн 27.1.7, 42 дугаар зүйлийн 42.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Нотариатын

822505000311

тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус байгууллагын орон нутгийн төсвийн санхүүжилт өмнөх оноос 101,372.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Тайлант онд татаас санхүүжилтийн 7,860.0 мянган төгрөгийн авлага үүссэнийг бүртгэл тайланд тусгасан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд төсвийн захирагч 15 зорилтын хүрээнд 95 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, 95.2 хувьтай дүгнэгдсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРБҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

(ТӨГРӨГ)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	37,000,200.00	25,360,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	19,500,200.00	7,860,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	17,500,000.00	17,500,000.00
33510	Байгууллагаас авах авлага	17,500,000.00	17,500,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	98,330,413.91	103,475,413.91
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	53,330,398.91	58,475,398.91
35410	Бичиг хэргийн материал	260,000.00	260,000.00
35420	Аж ахуйн материал	53,070,398.91	58,215,398.91
35600	Мал амьтад	45,000,015.00	45,000,015.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	19,992,000.00
36300	Тэжээлийн нөөц	-	19,992,000.00
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>135,330,613.91</b>	<b>148,827,413.91</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,765,180,712.45	1,864,925,255.29
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,650,522,212.49	1,750,579,255.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,220,183,496.87	1,219,740,228.87
39202	Хуримтлагдсан элэгдэл	(300,051,876.10)	(286,303,588.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	165,897,920.00	303,199,999.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(61,807,292.67)	(110,756,666.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	59,308,590.00	62,631,051.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,168,147.56)	(21,354,248.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,336,055.00	28,460,006.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,313,979.16)	(11,786,275.84)
39209	Зам, гүүрийн байгууламж	99,800,000.00	99,800,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(1,330,666.68)	(5,322,666.72)
39214	Бусад үндсэн хөрөнгө	655,742,191.30	698,077,330.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(183,074,078.51)	(225,805,914.73)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	114,658,499.96	114,346,000.00
39301	Програм хангамж	625,000.00	625,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(312,500.04)	(625,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	114,346,000.00	114,346,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,765,180,712.45</b>	<b>1,864,925,255.29</b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,900,511,326.36</b>	<b>2,013,752,669.20</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,656,778.00	1,453,442.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	3,656,778.00	1,453,442.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	3,656,778.00	1,453,442.00
41361	Байгууллагад төлөх өглөг	3,656,778.00	1,453,442.00
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,656,778.00</b>	<b>1,453,442.00</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,896,854,548.36	2,012,299,227.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	205,561,280.37	205,561,280.37
511001	Засгийн газрын оруулсан капитал загийн газрын сан	205,561,280.37	205,561,280.37
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,576,739,756.74	1,697,936,215.50
51210	Өмнөх үеийн үр дүн	958,782,873.00	1,582,491,536.66
51220	Тайлант үеийн үр дүн	617,956,883.74	115,444,678.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	114,553,511.25	108,801,731.33
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,896,854,548.36</b>	<b>2,012,299,227.20</b>
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,900,511,326.36</b>	<b>2,013,752,669.20</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,057,565,583.00</b>	<b>1,043,728,829.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	140,309,283.00	25,100,529.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138,814,283.00	6,945,529.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,495,000.00	18,155,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	917,256,300.00	1,018,628,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	917,256,300.00	1,018,628,300.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>784,333,463.00</b>	<b>253,532,641.19</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	784,333,463.00	253,532,641.19
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	754,278,463.00	249,987,641.19
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	30,055,000.00	3,545,000.00
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,841,899,046.00</b>	<b>1,297,261,470.19</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,223,942,162.26</b>	<b>1,181,816,791.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,138,332,084.43	1,109,006,739.06
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	593,963,854.91	652,378,207.08
210101	Үндсэн цалин	593,963,854.91	367,702,839.01
210102	Нэмэгдэл	-	284,675,368.07
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	74,250,000.00	81,305,275.24
210201	Тэтгэврийн даатгал	50,754,800.00	55,481,389.43
210202	Тэтгэмжийн даатгал	5,873,800.00	6,393,273.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,936,900.00	3,196,636.80
210204	Ажилгүйдлийн даатгал	2,936,900.00	3,197,636.80
210205	Эрүүл мэндийн даатгал	11,747,600.00	13,036,338.61
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	50,310,755.26	56,981,609.39
210301	Гэрэл, цахилгаан	4,359,277.26	6,327,945.39
210302	Түлш, халаалт	45,451,478.00	50,153,664.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	40,795,273.00	31,019,880.00
210401	Бичиг хэрэг	4,655,000.00	2,002,800.00
210402	Тээвэр, шатахуун	27,000,553.00	23,236,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,304,420.00	2,199,620.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,415,300.00	3,580,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,500,000.00	1,495,200.00
210604	Урсгал засвар	9,500,000.00	1,495,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	18,000,000.00	16,079,200.00
210702	Дотоод албан томилолт	18,000,000.00	16,079,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	50,781,520.00	56,813,269.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,236,720.00	54,627,489.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	493,588.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	636,500.00

**Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210807	Газрын төлбөр	500,000.00	689,692.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>300,730,681.26</b>	<b>212,934,098.35</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,103,200.00	45,460,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	990,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	164,627,481.26	166,483,098.35
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>85,610,077.83</b>	<b>72,810,052.29</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>42,702,130.00</b>	<b>1,200,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	32,730,630.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,971,500.00	1,200,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>42,907,947.83</b>	<b>71,610,052.29</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,907,947.83	71,610,052.29
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,223,942,162.26</b>	<b>1,181,816,791.35</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>617,956,883.74</b>	<b>115,444,678.84</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>617,956,883.74</b>	<b>115,444,678.84</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

(төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,106,567,803.00</b>	<b>1,063,229,029.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>189,311,503.00</b>	<b>44,600,729.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138,814,283.00	6,945,529.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	50,497,220.00	37,655,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>917,256,300.00</b>	<b>1,018,628,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	917,256,300.00	1,018,628,300.00
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,106,567,803.00</b>	<b>1,063,229,029.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,093,167,803.00</b>	<b>1,046,989,029.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>985,786,577.17</b>	<b>966,318,976.71</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>602,492,906.91</b>	<b>652,378,207.08</b>
210101	Үндсэн цалин	602,492,906.91	367,702,839.01
210102	Нэмэгдэл	-	284,675,368.07
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>74,250,000.00</b>	<b>81,305,275.24</b>
210201	Тэтгэврийн даатгал	50,754,800.00	55,481,389.43
210202	Тэтгэмжийн даатгал	5,873,800.00	6,393,273.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,936,900.00	3,196,636.80
210204	Ажилгүйдлийн даатгал	2,936,900.00	3,197,636.80
210205	Эрүүл мэндийн даатгал	11,747,600.00	13,036,338.61
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>46,653,977.26</b>	<b>59,184,945.39</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,359,277.26	6,327,945.39
210302	Түлш, халаалт	41,794,700.00	52,357,000.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>38,334,973.00</b>	<b>28,419,880.00</b>
210401	Бичиг хэрэг	4,655,000.00	2,002,800.00
210402	Тээвэр, шатахуун	27,000,553.00	20,636,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,304,420.00	2,199,620.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	-

ГАА-2026/052/НА-СТА-ТШЗ

**Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,955,000.00	3,580,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,500,000.00</b>	<b>1,495,200.00</b>
210604	Урсгал засвар	9,500,000.00	1,495,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>18,000,000.00</b>	<b>16,079,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	18,000,000.00	16,079,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>57,481,520.00</b>	<b>81,005,269.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,936,720.00	78,819,489.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	493,588.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	636,500.00
210807	Газрын төлбөр	500,000.00	689,692.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>139,073,200.00</b>	<b>46,451,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	139,073,200.00	45,460,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	990,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>107,381,225.83</b>	<b>80,670,052.29</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>44,973,078.00</b>	<b>1,200,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	35,001,578.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,971,500.00	1,200,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>62,408,147.83</b>	<b>79,470,052.29</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,907,947.83	71,610,052.29
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	19,500,200.00	7,860,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)</b>	<b>1,093,167,803.00</b>	<b>1,046,989,029.00</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>13,400,000.00</b>	<b>16,240,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>13,400,000.00</b>	<b>16,240,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>13,400,000.00</b>	<b>16,240,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,400,000.00	16,240,000.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>13,400,000.00</b>	<b>16,240,000.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(13,400,000.00)</b>	<b>(16,240,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>14</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>15</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

( төгрөг)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	205,561,280.37	118,924,068.17	954,412,316.08	1,278,897,664.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,370,556.92	4,370,556.92
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>205,561,280.37</b>	<b>118,924,068.17</b>	<b>958,782,873.00</b>	1,283,268,221.54
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(4,370,556.92)	-	(4,370,556.92)
C09	Тайлант үеийн үр дүн	-	-	617,956,883.74	617,956,883.74

**Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

C10	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	-	-
C11	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>205,561,280.37</b>	<b>114,553,511.25</b>	<b>1,576,739,756.74</b>	1,896,854,548.36
C12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	5,751,779.92	5,751,779.92
C13	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>205,561,280.37</b>	<b>114,553,511.25</b>	<b>1,582,491,536.66</b>	1,902,606,328.28
C14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(5,751,779.92)	-	(5,751,779.92)
C19	Тайлант үеийн үр дүн	-	-	115,444,678.84	115,444,678.84
C20	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>205,561,280.37</b>	<b>108,801,731.33</b>	<b>1,697,936,215.50</b>	2,012,299,227.20

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

(төгрөг)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Цэвэр гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,053,312,400.00</b>	<b>947,018,247.71</b>	<b>106,294,152.29</b>	<b>90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,053,312,400.00	947,018,247.71	106,294,152.29	<b>90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,034,612,400.00	945,818,247.71	88,794,152.29	<b>91</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	693,469,400.00	652,378,207.08	41,091,192.92	<b>94</b>
210101	Үндсэн цалин	385,069,400.00	367,702,839.01	17,366,560.99	<b>95</b>
210102	Нэмэгдэл	308,400,000.00	284,675,368.07	23,724,631.93	<b>92</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	86,683,700.00	81,305,275.24	5,378,424.76	<b>94</b>
210201	Тэтгэврийн даатгал	58,944,900.00	55,481,389.43	3,463,510.57	<b>94</b>
210202	Тэтгэмжийн даатгал	6,934,800.00	6,393,273.60	541,526.40	<b>92</b>
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,467,300.00	3,196,636.80	270,663.20	<b>92</b>
210204	Ажилгүйдлийн даатгал	3,467,300.00	3,197,636.80	269,663.20	<b>92</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	13,869,400.00	13,036,338.61	833,061.39	<b>94</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	61,857,000.00	59,184,945.39	2,672,054.61	<b>96</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,000,000.00	6,327,945.39	2,672,054.61	<b>70</b>
210302	Түлш, халаалт	52,357,000.00	52,357,000.00	-	<b>100</b>
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	500,000.00	-	<b>100</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,412,000.00	22,071,840.00	4,340,160.00	<b>84</b>
210401	Бичиг хэрэг	2,518,000.00	2,002,800.00	515,200.00	<b>80</b>
210402	Тээвэр, шатахуун	19,480,000.00	16,823,920.00	2,656,080.00	<b>86</b>
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	2,199,620.00	200,380.00	<b>92</b>
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	-	120,000.00	<b>0</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,394,000.00	1,045,500.00	348,500.00	<b>75</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,500,000.00	2,500,000.00	-	<b>100</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,500,000.00	-	<b>100</b>
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	18,100,000.00	16,079,200.00	2,020,800.00	<b>89</b>
210702	Дотоод албан томилолт	18,100,000.00	16,079,200.00	2,020,800.00	<b>89</b>

**Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	106,380,000.00	77,847,780.00	28,532,220.00	<b>73</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	102,700,000.00	75,662,000.00	27,038,000.00	<b>74</b>
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00	-	<b>100</b>
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,430,000.00	493,588.00	936,412.00	<b>35</b>
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	66,000.00	84,000.00	<b>44</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	636,500.00	363,500.00	<b>64</b>
210807	Газрын төлбөр	800,000.00	689,692.00	110,308.00	<b>86</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	39,210,300.00	34,451,000.00	4,759,300.00	<b>88</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,210,300.00	33,460,200.00	3,750,100.00	<b>90</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	990,800.00	1,009,200.00	<b>50</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	18,700,000.00	1,200,000.00	17,500,000.00	<b>6</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	18,700,000.00	1,200,000.00	17,500,000.00	<b>6</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,700,000.00	1,200,000.00	17,500,000.00	<b>6</b>
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,053,312,400.00</b>	<b>947,018,247.71</b>	<b>106,294,152.29</b>	<b>90</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,053,312,400.00	947,018,247.71	106,294,152.29	<b>90</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,053,312,400.00	947,018,247.71	106,294,152.29	<b>90</b>
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-		

**2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан**

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Цэвэр гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>44,600,729.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	44,600,729.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	36,740,729.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,348,040.00
210401	Бичиг хэрэг	-
210402	Тээвэр, шатахуун	3,813,040.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,535,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,495,200.00
210604	Урсгал засвар	1,495,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,897,489.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,897,489.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	7,860,000.00
213404	Хөрөнгийн	
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	7,860,000.00
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213502	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,860,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>44,600,729.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>44,600,729.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,945,529.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,655,200.00

## Гурав. Аудитын илрүүлэлт

### 3.1 Аудитаар бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup> илрээгүй.

Залруулагдаагүй 26,837.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 26,837.8 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч 3 зөвлөмж хүргүүлсэн.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Нэг: Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой**

Илрүүлэлт: Сумын Засаг даргын Тамгын газрын даргад нотариатын ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг үндсэн цалингийн 20.0 хувиар тооцож 3,079.2 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нотариатын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5-т "Нотариатч энэ хуульд зааснаас бусад үйлчилгээний хөлс, зардал болон шагнал, урамшуулал авахыг хориглоно", гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндэслэлгүйгээр нэмэгдэл хөлс олгож байгаа зөрчлийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх.

#### **Хоёр: Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой**

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгийн зардлын төсвөөс 23,758.6 мянган төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нярвын дансаар зарцуулсан бөгөөд санхүүгийн анхан шатны баримт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна", Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн сангийн үйл ажиллагааны журам", ТЭЗ-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,  
ГАА-2026/052/НА-СТА-ТШЗ

Өгсөн зөвлөмж: Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу санхүүгийн үйл ажиллагаа явуулж, анхан шатны баримт материалын бүрдлийг хангаж ажиллаж, няравын дансаар дамжуулан гүйлгээ хийж байгаа зөрчлийг арилгах

**Гурав: Орлогын бүрдүүлэлттэй холбоотой**

Илрүүлэлт: Засаг даргын Тамгын газрын байранд өрөө түрээслүүлж үйл ажиллагааны орлого төвлөрүүлж байгаа боловч өөрийн орлогыг төлөвлөөгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах", 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын өөрийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг төлөвлөн, үндсэн дансаар дамжуулан журмын дагуу зарцуулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөг)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг даргын Тамгын газар	Нотариатын үйлчилгээний нэмэгдлийг үндсэн цалингийн 20.0 хувиар тооцож 3,079.2 мянган төгрөгийг олгосон.	1	3,079.2	-	-	--	-	1	3,079.2	-	-
	Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 23,758.6 мянган төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нярвын дансаар дамжуулсан бөгөөд санхүүгийн анхан шатны баримт хангалтгүй.	1	23,758.6	-	-	-	-	1	23,758.6	-	-
	Засаг даргын Тамгын газрын байранд өрөө түрээслүүлж орлого олж байгаа боловч өөрийн орлогыг төлөвлөөгүй.	1	-	-	-	-	-	-	1	-	-
<b>Нийт</b>		<b>3</b>	<b>26,837.8</b>	-	-	-	-	<b>3</b>	<b>26,837.8</b>	-	-